



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/417

Булган сум

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны VIII/55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2026 онд нийлүүлэгдсэн 1,148,319,100 (нэг тэрбум нэг зуун дөчин найман сая гурван зуун арван есөн мянга нэг зуу) төгрөгийн данс бүртгэлд бүртгэх хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ, ажлын даалгавар, зарлагын баримт, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтын дор хүлээн авсан актад үндэслэн данс бүртгэлд бүртгэж, тайланг 2026 оны 07 дугаар сарын 31-ний дотор Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, 2026 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай тооцоо нийлж баталгаажуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
 06 дугаар сарын 10-ны/ний өдрийн
 А.М.А. дугаар захирамжийн хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

(төгрөгөөр)

д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнийн дүн	Өмчид бүртгэж авах сум, байгууллага
1	2	3	4	5	6
1	УДД-4 төвд насос, дагалдах хэрэгсэл (Булган аймаг Булган сум 6-р баг)	Ширхэг	1	26,800,000	"Булган МЭЭЖ" ОНӨХХК
2	Даралтны эталон, дулаан хэмжигч тоног төхөөрөмж (Стандарт хэмжил зүйн хэлтэс)	Ширхэг	1	46,200,000	Стандарт хэмжил зүйн хэлтэс
3	Шүдний бор машин 2ш (Баяннуур, Гурванбулаг)	Ширхэг	2	29,080,000	Баяннуур, Гурванбулаг сумдын ЭМТ
4	БТСГ-ын харьяа усан спорт сургалтын төвийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	Ширхэг	1	20,000,000	Биеийн тамир спортын газар
5	Усан хангамжийн худгийн цэвэршүүлэгч шүүлтүүр (Баяннуур сум)	Ширхэг	1	45,314,500	Баяннуур сумын ЗДТГ
6	Бохир соруулах техникээр хангах (Хишиг-Өндөр, Могод, Орхон, Хангал Хялганат тосгон)	Ширхэг	4	230,280,000	Хишиг-Өндөр, Могод, Орхон, Хангал сумдын ЗДТГ, Хялганат тосгоны ЗАА
7	Сумын төвийн орон сууцыг хог ангилан ялгах хогийн савтай болгох (Булган сум 30 ш)	Ширхэг	30	74,850,000	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги
8	Сумдын айл өрхийг ангилан ялгах хогийн савтай болгох (Булган сум 160ш, Хангал сум 40ш)	Ширхэг	200	183,564,500	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги, Хангал сумын ЗДТГ
9	Хогийн төвлөрсөн цэгийг хашаажуулах (Рашаант сум)	Ширхэг	1	69,920,100	Рашаант сумын ЗДТГ
10	Ус бохирдохоос сэргийлэх авто замын дагуу болон жуулчид ихээр цугладаг үзэсгэлэнт газар, нуурын эрэгт стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж (Тэшиг сум Харгал нуур)	Ширхэг	1	60,000,000	Тэшиг сумын ЗДТГ
11	Ус бохирдохоос сэргийлэх авто замын дагуу болон жуулчид ихээр цугладаг үзэсгэлэнт газар, нуурын эрэгт стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламж (Тэшиг сум Харгал нуур)	Ширхэг	1	55,010,000	Тэшиг сумын ЗДТГ

1	2	3	4	5	6
12	Бохирдсон хөрсийг ариутгах зориулалттай дук автомашин худалдан авах зардал (Дашинчилэн сум)	Ширхэг	1	65,800,000	Дашинчилэн сумын ЗДТГ
13	Орчны бохирдлыг бууруулах зорилгоор хог тээвэрлэх автомашин худалдан авах зардал (Булган сум)	Ширхэг	1	116,500,000	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги
14	Байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох ажилд шаардлагатай тоног төхөөрөмж	Ширхэг	1	15,000,000	Аймгийн ЗДТГ
15	Байгаль орчны эсрэг гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор хяналт шалгалт хийх тусгай тоноглодсон авто машин худалдан авах	Ширхэг	1	95,000,000	Аймгийн ЗДТГ
Нийт хөрөнгийн дүн				1,148,319,100	

--o00o--